

**ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН УЛСЫН ИХ
ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙН АНХНЫ ХЭЛЭЛЦҮҮЛГИЙГ ЯВУУЛСАН
ТАЛААРХ ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2025 оны 04 дүгээр
сарын 22-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалан

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Э.Батшугараас 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын чуулганы 2025 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлсэн.

Эдийн засгийн байнгын хороо 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдаанаараа дээрх хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасныг баримтлан явуулж, дараах санал, дүгнэлтийг гарган Та бүхэнд танилцуулж байна.

Улсын Их Хурлын гишүүдээс хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн тогтоолын төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй 11 саналын томьёолол бичгээр урьдчилан ирүүлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан олон улсын жишиг, зарчмыг баримтлан Монголбанкнаас тогтоосон нөхцөл, шаардлагыг үндэслэн зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээд нь зээлдэгчийн зээлжих чадварын зэрэглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсөө өөрөө тогтоох, Улсын Их Хурлын гишүүн Л.Соронзонболд төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан зээлдэгчийн мэдээллийг таван жил хадгалах агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналын томьёоллууд гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжлээ.

Мөн хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг Монголбанк батлах агуулга бүхий зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал тогтоолын төслийн 2 дугаар зүйлийг зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн онооны аргачлал, бүтээгдэхүүн, үйлчилгээний хөлсийг тогтоох үндсэн зарчим, нөхцөл шаардлагыг холбогдох байгууллагуудын үйл ажиллагаанд

нэвтрүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороонд даалгах агуулгаар өөрчлөн найруулах зарчмын зөрүүтэй саналын томьёоллыг гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Түүнчлэн тогтоолын төслийн 1 дүгээр эүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Р.Сэддорж зээлдэгчийн зээлийн мэдээллийг зээлийн лавлагаанд гурван жилээр тусгах гэсэн агуулга бүхий зарчмын зөрүүтэй саналын томьёолол гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.22 дахь хэсэгт заасны дагуу Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж, олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн Та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Зээлийн мэдээллийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн "Хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлт болон зарчмын зөрүүтэй саналын томьёоллуудыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Л.СОРОНЗОНБОЛД

ТУС3761 9023051390 9087184